



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА Х.БУЛГАНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Цэндийн БААТАРХҮҮ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-14-67, Факс: 32-70-16
E-mail: baatarkhuu@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025 11 07 № ЗХХ-03/12717
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Ц.БААТАРХҮҮ

О.АЛТАНГЭРЭЛ

О.АМГАЛАНБААТАР

Н.АЛТАНХУЯГ

Д.БАТБАЯР

Ж.БАТСУУРЬ

Х.БАТТУЛГА

П.БАТЧИМЭГ

Ж.БАЯРМАА

Ж.БАЯСГАЛАН

ЗЗБХ

2025.11.11

0000228

Б.БЕЙСЕН

Х.БОЛОРМАА

Ш.БЯМБАСҮРЭН

А.ГАНБААТАР

Г.ГАНБААТАР

С.ГАНБААТАР

Д.ГАНБАТ

Я.ГАНТӨМӨР

Б.ЖАРГАЛАН

Д.ЖАРГАЛСАЙХАН

Ч.ЛОДОЙСАМБУУ

Ц.МӨНХБАТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

П.МӨНХТУЛГА

Ц.МӨНХТУЯА

С.ОДОНТУЯА

Э.ОДБАЯР

Г.ОЧИРБАТ

Б.ПУНСАЛМАА

Б.ПҮРЭВДОРЖ

Р.СЭДДОРЖ

Ц.ТУВААН

Б.ТҮВШИН

Х.ТЭМҮҮЖИН


Г.ХОСБАЯР

Д.ЦОГТБААТАР

О.ЦОГТГЭРЭЛ

С.ЦЭНГҮҮН

Ө.ШИЖИР

Handwritten signatures and lines. On the left, a large, stylized signature with a long horizontal stroke extending to the left. On the right, two smaller signatures, one above the other, with a vertical line passing through them.

Д.ЭНХТУЯА
С.ЭРДЭНЭБОЛД
Р.ЭРДЭНЭБҮРЭН

БАТЛАВ:

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.БААТАРХҮҮ

“УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ОЛГОЛТЫН ШИЙДВЭР, ГАЗАР АШИГЛАЛТЫН БАЙДАЛ, ГАРСАН АЛДАА, ЗӨРЧИЛ, ГАЗАР ОЛГОЛТЫН ҮР ДАГАВАРТ БИЙ БОЛСОН НИЙТИЙН ЭРХ АШИГТ ХАРШЛАХ АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ЗОРИЛГООР ХОЛБОГДОХ ТОГТООЛ, ШИЙДВЭР, ГАЗАР ОЛГОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал (УИХ) цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор байгуулна.” гэж тус тус заасан.

1992 онд батлагдсан Үндсэн Хуулийн дараа буюу 1994 онд анх Газрын тухай хууль батлагдаж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулж ирсэн байна. Харин 2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аас Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаар өнөөдрийг хүртэлх газар олголттой холбоо газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тухай харилцааг зохицуулж иржээ.

Газрын тухай хуулиар газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах хүрээнд Засгийн газраас журам батлаж, мөрдүүлэн, улмаар бий болсон эрх зүйн орчны хүрээнд Засгийн газар, орон нутгийн Засаг захиргааны нэгж газар олголтын асуудлыг шийдвэрлэж иржээ.

Нийслэл хотын нийтийн эдэлбэр газарт Газрын тухай хуулийн 12.2-т заасан хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай болон иргэд, олон нийтийн амьдрах, ажиллах аятай таатай орчныг бүрдүүлэх, хотын стандартыг хэрэгжүүлэхэд шаардлагатай

авто зогсоол, хүүхдийн тоглоомын талбай, соёл, амралтын цогцолбор зэрэг нийтээрээ ашиглах газар хамаарна.

1.2.Практик шаардлага

Нийслэл Улаанбаатар хот нь 9 дүүргийн эдэлбэр газар хамаарах нийт 4.704.4 км хавтгай дөрвөлжин газар нутагтай атлаа Улаанбаатар хотын төв хэсэгт сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд ерөнхий төлөвлөлт, зохион байгуулалтгүйгээр газрыг хяналтгүй, эмх замбараагүй олгосон нь нийгэмд үүсээд байгаа өнөөгийн олон асуудлын шалтгаан болсон байна.

Нийслэл хотын нийтийн эдэлбэр газарт газар олголт хийхдээ Хот тосгоны төлөвлөлтийн норм, дүрмийг баримтлаагүйгээс хуучин хорооллын дунд байх нийтийн эдэлбэр газарт нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбайд, улмаар ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийснээс хамаарч хэт төвлөрөл бий болж, хотын оршин суугчдын ая тух алдагдах үр дагавар бий болсон байна.

Нийслэл хотын эдэлбэр газарт 1992 оноос хойш шинээр газар олголт хийсэн байдлаас харахад хот төлөвлөлтийн бодлого төлөвлөлт, стандарт, норм, дүрэм хангагдаагүй, хотын дэд бүтцийн төлөвлөлт уялдаагүй, хот доторх авто замын сүлжээг анхнаас нь тооцож төлөвлөж газар олгоогүйгээс замын уулзвар нэвтрүүлэх хүчин чадалд хэт ачаалал үүсч, авто зам дээр олон цагаар түгжрэл үүсч, иргэдийн цаг, мөнгө, хөрөнгөд их хэмжээний хохирол учруулах, уур бухимдал төрүүлэх асуудлыг үүсгэжээ. Энэ байдал засагдалгүй 30 гаруй жилийг дамнан өнөөдөр ч хууль бус газар олголт хийгдсээр байгаа асуудлыг УИХ-ын түвшинд хянан шалгах түр хороо бйагуулах замаар судлан, дүгнэлт гаргаж, Засгийн газарт чиглэл өгөх шаардлага үүссэн байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөлд дараах агуулгыг тусгана.

- 1.Хянан шалгах түр хороог байгуулах бүрэлдэхүүн, ажиллах хугацаа;
- 2.Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаар;
- 3.Тогтоолыг дагаж мөрдөх хугацаа.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан үндэслэл, шалгуурын дагуу боловсруулна.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдснаар Улаанбаатар хотын газар олголтын хүрээнд 1992 оноос өнөөг хүртэл гарсан шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа, зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох, цаашид газар ашиглалт, өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал дүгнэлт гаргах зорилгоор УИХ-ын Хянан шалгах түр хороо байгуулагдаж, доор дурдсан хүрээнд хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлнэ.

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын гаргасан газар олголттой холбоотой 1992-оос 2025 оны шийдвэрүүд;
- Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон байдал;
- Нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх;
- Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийгдсэн байдал;
- Газар олголтын ил тод байдал, мэдээллийн сангийн бодит байдал;

Одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэргийг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах юм.

Дөрөв.Тогтоолын төсөл нь бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах, уг тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой бүрэн нийцэж байгаа болно. Тогтоолын төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

**“ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын энэхүү тогтоолын төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын газар олголттой холбоотой 1992 оноос өнөөг хүртэлх бүх шийдвэр, үйл ажиллагааг иж бүрэн шалгаж, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн зөрчил, алдаа дутагдлыг илрүүлж, цаашдын бодлого, хууль эрх зүйн шинэчлэлд шаардлагатай санал дүгнэлтийг боловсруулахад оршино. Тогтоолыг Монгол Улсын Үндсэн хуулийн хорин наймдугаар зүйлийн хоёр дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хорин наймдугаар зүйлийн хорин наймдугаар хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн зургаа дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт болон гучин хоёрдугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3, мөн гучин гуравдугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсгийг үндэслэн боловсруулсан бөгөөд эдгээр нь Улсын Их Хуралд хяналт шалгалт хийх, түр хороо байгуулах, шалгалтын үр дүнд дүгнэлт, санал гаргах бүрэн эрхийг олгож байна.

Тусгай шалгалтын гол зорилт нь Улаанбаатар хотын газар олголтын шийдвэрүүдийн хэрэгжилт, хууль зөрчсөн эсэх, нийтийн эрх ашигт хохирол учруулсан асуудлыг илрүүлэх бөгөөд үүний үр дүнд газар ашиглалт, өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бий болгох бодитой санал дүгнэлт гаргах явдал юм. Шалгалтын хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын 1992-2025 онд гаргасан газар олголттой холбоотой бүх шийдвэрийг судлан дүгнэхээс гадна Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон бодит байдал, нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийсэн байдал, газар олголтын ил тод байдал болон мэдээллийн сангийн үнэн зөв, одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэрэг чиглэлээр иж бүрэн хяналт шалгалт хийнэ.

Энэ ажлыг хэрэгжүүлэхийн тулд Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог байгуулж, олонхыг төлөөлсөн таван гишүүн, цөөнхийг төлөөлсөн дөрвөн гишүүнтэйгээр бүрдүүлэх бөгөөд гишүүдийн нэрсийг тогтоол батлагдах үед тодорхой тусгана. Түр хороо нь шалгалтыг иж бүрэн зохион байгуулж, нотолгоо баримт дээр тулгуурласан тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн гучин хоёрдугаар зүйлийн 32.7-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

Тогтоол нь 2025 оны есдүгээр сарын тодорхой өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэх бөгөөд ингэснээр нийслэл Улаанбаатар хотын газар олголттой холбоотой өнгөрсөн гуч гаруй жилийн бодит байдлыг бүхэлд нь нягталж, хууль зөрчсөн шийдвэр, нийтийн эрх ашгийг хохироосон үйлдлийг илрүүлэх, газар ашиглалт болон

өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бий болгох бодлого, хууль эрх зүйн шинэчлэл хийхэд суурь мэдээлэл, чухал баримт нотолгоо болох юм.

Нэг дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Улаанбаатар хотын газар олголтын шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа, зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох тогтоол, шийдвэр, газар олголтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх” гэж тусгасан.

Хоёр дахь заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- 1/.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын гаргасан газар олголттой холбоотой 1992-оос 2025 оны шийдвэрүүд;
- 2/.Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон байдал;
- 3/.Нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх;
- 4/.Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийгдсэн байдал;
- 5/.Газар олголтын ил тод байдал, мэдээллийн сангийн бодит байдал;
- 6/.Одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэргийг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах.

Гурав дахь заалтад Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг тусгасан.

Дөрөв дэх заалтаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд гаргасан тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд даалгахыг даалгасан.

ТӨСӨЛ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрийн ордон,
Улаанбаатар хот

Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2, 32.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын газар олголтын хүрээнд 1992 оноос өнөөг хүртэл гарсан шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа, зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох, цаашид газар ашиглалт, өмчлөлийн ил тод, шударга тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн санал дүгнэлт гаргах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг “Улаанбаатар хотын газар олголтын шийдвэр, газар ашиглалтын байдал, гарсан алдаа, зөрчил, газар олголтын үр дагаварт бий болсон нийтийн эрх ашигт харшлах асуудлыг тодорхойлох зорилгоор холбогдох тогтоол, шийдвэр, газар олголтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх”-ээр тогтоосугай.

2.Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай:

1/.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга болон холбогдох захиргааны байгууллагын гаргасан газар олголттой холбоотой 1992-оос 2025 оны шийдвэрүүд;

2/.Газрын тухай хуулийн хэрэгжилт, газрыг өмчлөл, эзэмшил, ашиглалтын зориулалтаар олгосон байдал;

3/.Нийтийн эзэмшлийн газар, ногоон байгууламж, гол усны хамгаалалтын бүс зэрэг хуульд хориглосон бүсэд газар олгосон эсэх;

4/.Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, эмнэлгийн эдэлбэр газарт газар олголт хийгдсэн байдал;

5/.Газар олголтын ил тод байдал, мэдээллийн сангийн бодит байдал;

6/.Одоогийн эрх зүйн орчин, хэрэгжилтийн зөрчил, цаашид өөрчлөлт оруулах шаардлага зэргийг судлан хяналт шалгалт хийх, санал, дүгнэлт гаргах.

3.Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Олонхыг төлөөлөн:

.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн

Цөөнхийг төлөөлөн:

.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн
.....	Улсын Их Хурлын гишүүн

4.Тусгай шалгалтыг иж бүрэн хэрэгжүүлж, тайлан, санал, дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг 2025 оны 09 дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.